



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/25/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70273465 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.16 № 01/55
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН СОЁЛ УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГА Б.ТУНГАЛАГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Соёл урлагийн газар нь Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан "Нүүдэлчин Монгол-2022" соёлын биет бус өвийн их наадамд оролцож, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу "Соёлын ажилтны баяр"-ын хүрээнд соёлын орон зай-г зохион байгуулж, Аймгийн нутаг дэвсгэрт бүртгэлтэй орон нутаг, улс, аймгийн хамгаалалтай түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын улсын тооллого хийж, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нарын улсын тооллогод цахимаар хамруулсан байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0	6,443,583.09
33	АВЛАГА	0	1,185,381.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	1,185,381.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0	5,258,202.09
35400	Хангамжийн материал	0	5,258,202.09
35410	Бичиг хэргийн материал	0	1,044,130.00
35420	Аж ахуйн материал	0	3,040,572.09
35430	Сэлбэг хэрэгсэл	0	308,500.00
35470	Бусад хангамжийн материал	0	865,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0	41,003,283.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0	41,003,283.12
39200	Биет хөрөнгө	0	39,628,283.12
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	0	29,835,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	0	(3,087,157.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0	13,207,701.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	0	(328,060.08)
39300	Биет бус хөрөнгө	0	1,375,000.00
39301	Програм хангамж	0	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0	(125,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0	47,446,866.21
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0	47,446,866.21
51	Засгийн газрын хувь оролцоо	0	47,446,866.21
51200	Хуримтлагдсан үр дүн	0	47,446,866.21
51220	Тайлант үеийн үр дүн	0	47,446,866.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0	47,446,866.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0	284,633,501.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	12,135,601.00
120	Нийтлэг татварын бус орлого	0	12,135,601.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	11,816,601.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	319,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0	272,497,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0	200,455,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	200,455,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	59,981,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	59,981,000.00
1330	Төсвийн захирагчдаас	0	12,061,200.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	12,061,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0	237,186,634.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0	237,186,634.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0	139,181,137.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0	70,547,624.42
210101	Үндсэн цалин	0	54,914,653.30
210102	Нэмэгдэл	0	5,824,703.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	6,350,000.00
210104	Урамшуулал	0	3,458,267.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0	9,370,819.52
210201	Тэтгэврийн даатгал	0	6,491,153.76
210202	Тэтгэмжийн даатгал	0	682,581.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	587,303.98
210204	Ажилгүйдлийн даатгал	0	141,519.87
210205	Эрүүл мэндийн даатгал	0	1,468,260.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0	1,837,120.00
210301	Гэрэл, цахилгаан	0	790,167.00
210302	Түлш, халаалт	0	902,600.00
210303	Цэвэр, бохир ус	0	144,353.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0	9,217,536.00
210401	Бичиг хэрэг	0	2,190,050.00

210402	Тээвэр, шатахуун	0	4,917,418.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	823,680.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	1,286,388.00
2105	Нормативт зардал	0	105,000.00
210502	Хоол, хүнс	0	105,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	4,420,955.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	4,420,955.91
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	43,682,081.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	40,141,864.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0	3,540,217.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0	98,005,497.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	1,150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	1,150,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0	96,855,497.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	96,855,497.06
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	0	47,446,866.21
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	0	47,446,866.21

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	0	272,497,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0	272,497,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0	212,516,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	212,516,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	59,981,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	59,981,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0	241,481,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0	241,481,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0	143,422,002.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0	71,733,005.42
210101	Үндсэн цалин	0	56,268,838.07
210102	Нэмэгдэл	0	5,685,899.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	6,320,000.00
210104	Урамшуулал	0	3,458,267.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0	9,370,819.52
210201	Тэтгэврийн даатгал	0	6,439,605.52
210202	Тэтгэмжийн даатгал	0	734,130.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	587,303.98
210204	Ажилгүйдлийн даатгал	0	141,519.87
210205	Эрүүл мэндийн даатгал	0	1,468,260.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0	1,837,120.00
210301	Гэрэл, цахилгаан	0	790,167.00
210302	Түлш, халаалт	0	902,600.00
210303	Цэвэр, бохир ус	0	144,353.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0	9,525,640.00
210401	Бичиг хэрэг	0	3,294,780.00
210402	Тээвэр, шатахуун	0	4,487,292.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	823,680.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	919,888.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	6,880,172.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	6,880,172.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	44,075,246.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	44,075,246.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0	98,059,497.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	1,150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	1,150,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0	96,909,497.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	96,909,497.06
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	31,016,400.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	31,016,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	31,016,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	31,016,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	31,016,400.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	(31,016,400.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	47,446,866.21	47,446,866.21
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0.00	0.00	47,446,866.21	47,446,866.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	212,516,900.00	116,278,673.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	212,516,900.00	116,278,673.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	212,130,900.00	116,078,673.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	150,133,900.00	71,733,005.42
210101	Үндсэн цалин	86,036,800.00	56,268,838.07
210102	Нэмэгдэл	43,000,000.00	5,685,899.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,200,000.00	6,320,000.00
210104	Урамшуулал	7,897,100.00	3,458,267.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,266,800.00	9,370,819.52
210201	Тэтгэврийн даатгал	14,461,400.00	6,439,605.52
210202	Тэтгэмжийн даатгал	1,701,300.00	734,130.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,361,100.00	587,303.98
210204	Ажилгүйдлийн даатгал	340,300.00	141,519.87
210205	Эрүүл мэндийн даатгал	3,402,700.00	1,468,260.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,276,000.00	1,837,120.00
210301	Гэрэл, цахилгаан	1,124,700.00	790,167.00
210302	Түлш, халаалт	823,000.00	902,600.00
210303	Цэвэр, бохир ус	328,300.00	144,353.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,427,400.00	6,558,587.00
210401	Бичиг хэрэг	2,569,000.00	3,176,780.00
210402	Тээвэр, шатахуун	1,204,000.00	1,638,239.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,286,700.00	823,680.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,367,700.00	919,888.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	14,911,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,984,800.00
210602	Тавилга	10,000,000.00	9,927,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,013,400.00	6,880,172.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,013,400.00	6,880,172.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,013,400.00	4,787,070.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,013,400.00	4,787,070.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	386,000.00	200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	386,000.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	386,000.00	200,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	212,516,900.00	212,516,900.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	212,516,900.00	212,516,900.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	212,516,900.00	212,516,900.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	23	23
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	11	11
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7
620003	Үйлчлэх ажилтан	3	3
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	11	11
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	59,363,729.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	59,363,729.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	58,413,729.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	2,967,053.00
210401	Бичиг хэрэг	-	118,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	2,849,053.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	16,104,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	16,104,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	39,342,176.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	39,342,176.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	950,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	950,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	950,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	59,981,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	59,981,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	59,981,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Соёл урлагийн газар нь орон нутгийн түвшинд үндэсний бахархал, эх хэл, уламжлал өв соёлоо дээдэлсэн, эх оронч, оюунлаг бүтээлч Монгол хүнийг хөгжүүлэх, улс орны хөгжлийн шинэ нөхцөл байдал, нийгмийн оюун сэтгэлгээний эрэлт хэрэгцээтэй уялдан нийтийн соёлын ойлголт, дэвшилтийг өргөн нэвтрүүлэх, соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалах, хүн амд төрөөс үзүүлэх соёлын олон талт үйлчилгээг өргөтгөн сайжруулахад соёлын салбарын хөгжлийг хангах чиг үүрэг бүхий Соёлын яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Соёл урлагийн газар нь 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 зорилтын хүрээнд 26 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан баталснаас хэрэгжилт 95,6%-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Соёл урлагийн газар нь соёл урлагийн хэлтэс-төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хариуцсан чиг үүрэгтэй, захиргаа удирдлагын хэлтэс-нийтлэг чиг үүрэгтэй бүтэц, зохион байгуулалттай ба тайлант онд Соёл урлагийн газрын дарга 1, захиргаа удирдлагын хэлтсийн дарга 1, соёл, урлагийн хэлтсийн дарга 1 мэргэжилтэн 6, үйлчилгээний ажилтан 2, бүгд 11 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Соёл урлагийн газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Соёлын тухай хууль

Төв аймгийн Соёл урлагийн газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн "Дотоод хяналт шалгалтын зөвлөл байгуулах тухай" А/11 тушаал, 5 хүний бүрэлдэхүүнтэй, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Соёл урлагийн газрын дотоод хяналт шалгалтын зөвлөл нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар арга хэмжээ төлөвлөж ажиллаагүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Соёл урлагийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Соёлын яамнаас албан ёсоор шинэчлэн ирүүлээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Соёл урлагийн газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 47,446.9 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	1,185.4	1,185.4
Бараа материал	0	5,258.2	5,258.2
Үндсэн хөрөнгө	0	41,003.3	41,003.3
Нийт хөрөнгө	0	47,446.9	47,446.9
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	0	47,446.9	47,446.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	0	47,446.9	47,446.9

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 онд байгуулагдаагүй байсан тул 2022 оны төсвийн төсөлд дээд шатны төсвийн захирагчид санал хүргүүлээгүй байна.

Төв аймгийн Соёл урлагийн газарт Соёлын сайдын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 1/2760 дугаар албан бичгийн хавсралтаар 2022 оны урсгал зардлын төсвийг 216,062.2 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн.

Тайлант хугацаанд батлагдсан төсөвт 2 удаа тодотгол хийж өөрчлөлт орсон байна. Монгол Улсын Соёлын сайдын 2022 оны 3 дугаар сарын 03-ний өдрийн 1/497 дугаар албан бичгийн хавсралтаар 211,939.8 мянган төгрөг, 2022 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 1/1209 дугаар албан бичгийн хавсралтаар 212,516.9 мянган төгрөг буюу 3,545.3 мянган төгрөгөөр буурч баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 /соёл урлаг/ хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 212,516.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 96,855.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 116,278.7 мянган төгрөг буюу 54,7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 96,238.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	71702 соёл урлаг 80101 үндсэн үйл ажиллагааны зардал	212,130.9	116,078.7	96,052.2	54,7
	71702 соёл урлаг 80802 ажил олгогчоос олгох тэтгэмж	386.0	200.0	186.0	51,8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Соёл урлагийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 59,981.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Соёл урлагийн газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар бичиг хэрэг, тээвэр шатахуунд 21,181.0 мянган төгрөг, бусад ажил үйлчилгээний зардалд 38,800.0 мянган төгрөг нийт 59,981.0 мянган төгрөг зарцуулж, 617.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71702	2022.01.01-2022.12.31	Соёл урлаг	Хөтөлбөр 54,7 %	212,516.9	116,278.7

Төв аймгийн Соёл урлагийн газар нь төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар нийт 96,855.5 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, дутуу зарцуулсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Соёлын сайдын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Соёл урлагийн газрын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан 2022 оны нийт зарлага 212,516.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 3,187.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,550.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Соёл урлагийн газрын нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Соёл урлагийн газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8 орлогын, 2 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Соёл урлагийн газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь Төв аймгийн Засаг даргын 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А/467 дугаар захирамжаар байгуулагдсан тул 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Соёл урлагийн газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 96,855.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 96,855.5 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1.Тус байгууллага тайлант онд санхүүгийн үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн 96,855.5 мянган төгрөгийг тусламж, санхүүжилтийн орлогод тусгаж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 3,119.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 3,119.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож хүргүүлээ.

5.2 Төлбөрийн акт

1. Тус байгууллага тайлант онд Соёлын ажилтны өдөрт зориулж албан хаагчдад зориулсан фудволка, хэвлэлд 2,242.0 мянган төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага

1. Тус байгууллага тайлант онд 2022 оны санхүүжилтийг 778.5 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх,” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2. Тус байгууллага тайлант онд 99.0 мянган төгрөгөөр нэрийн хуудас хэвлүүлсэн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх,” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн 96,855.5 мянган төгрөгийг тусламж, санхүүжилтийн орлогод тусгаж тайлагнасан байна	1	96,855.5					1	96,855.5				
Дүн	1	96,855.5					1	96,855.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Соёлын ажилтны өдөрт зориулж албан хаагчдад зориулсан фудволка, хэвлэл 2,242.0 мянган төгрөг зарцуулсан байна.	1	2,242.0	1	2,242.0								
Төсвийн хөрөнгөөр 778.5 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.	1	778.5			1	778.5						
Төсвийн хөрөнгөөр нэрийн хуудас 99.0 мянган төгрөгөөр хэвлүүлсэн байна.	1	99.0			1	99.0						
Дүн	3	3119.5	1	2242	2	877.5						